



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 4/131

Номгон


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 133 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журамын 4.1," Онцгой комиссын 2021 оны 35, 51, 52 тоот хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1.Аймгийн Онцгой комиссоос цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан зохион байгуулан, хэрэгжүүлж байгаа ажлын хүрээнд сум тус бүрт 5 сая төгрөгт багтааж түргэвчилсэн оношлуур болон эмчилгээний багц олгох ажилд зарцуулагдах 95 сая төгрөгийг Сум дундын Ойн ангийн өвс, тэжээлийн орлогоос, Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэх, Иргэн Б.Жанчивын өвс тээвэрлэж сумдад хүргэсэн шатахууны зардал 2,342,230 төгрөгийг шилжүүлж тооцоо дуусгахыг Сум дундын Ойн анги орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар (П.Уртнасан)-д зөвшөөрсүгэй.

2.Баянхонгор аймгийн Жинст сумын төвд хаврын шуурга, хүчтэй салхины нөлөөгөөр сумын төв нь их хэмжээний элсэнд өртсөн тул, Сум дундын Ойн анги орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлэх өвс, тэжээлийн 29,278,800 төгрөгнөөс 20 сая төгрөгийг сумын төвөөс элс зайлуулах ажилд зарцуулахыг Жинст сумын Засаг дарга (н.Батжаргалд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигтбаатар)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621011093

Аймгийн Засаг даргын 2021 оны 07
дугаар сарын 05-ны өдрийн
А/430 дугаар захирамжийн
хавсралт.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ДОТООДЫН ХАНДИВ ТУСЛАМЖИЙН МӨНГӨН
ХӨРӨНГӨӨС ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6	7
1	Түргэвчилсэн сорьц шинжилгээ	Аймгийн хэмжээнд түргэвчилсэн сорьц шинжилгээний нөөц бүрдүүлэх зардал	ш	10,000	16,000	160,000,000
2	Комбинзон зузаан	Халдвар хамгааллын хувцасны нөөц бүрдүүлэх зардал	ш	500	19,000	9,500,000
3	Комбинзон нимгэн		ш	191	10,000	1,910,000
4	Бээлий		хайрцаг	400	35,000	14,000,000
5	Бодис	Аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаа нэгдсэн ариутгал халдваргүйжүүлэлтэд шаардагдах бодисын зардлын тооцоо	хайрцаг	400	85,000	34,000,000
6	Хяналтын камер	3-р сургуулийн шинээр баригдсан дотуур байрыг тусгаарлах эмнэлгээр томилж, хяналтын камер суурьлуулах ажлын зардал	ш	1	717,000	717,000
7	Бичиг хэргийн материал	Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагаанд шаардагдах хэвлэмэл хуудас, бичгийн цаас, принтерийн хор, холбогдох бусад материалын зардал	ш	1	1,200,000	1,200,000
8	Тусгаарлах байрны зардал	"Соёмбо" зочид буудлыг тусгаарлах байраар томилон ажилуулсаны зардал	хоног	70	83,285	5,830,000
9	Эрдэнэмандал сургуулийн тусгаарлах эмнэлэг	Орны цагаан даавуу	ш	100	55,000	5,500,000
		Ус цэвэршүүлэгч баллантай ус	ш	4	97,500	390,000
		Цахилгаан тоног төхөөрөмж	ш	1	2,923,100	2,923,100
		Эмнэлгийн тоног төхөөрөмж	ш	8	14,637,500	117,100,000
Нийт зардлын дүн						351,870,100